



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/517

Ховд

Урьдчилгаа санхүүжилт олгож тооцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.1.г дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны "Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай" 7/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд дулаан түгээлтийн "Бадамлах дөл" компанид халаалт авдаг төсөвт байгууллагуудын халаалтын зардлын урьдчилгаа санхүүжилтэнд 150,000,000 төгрөг (нэг зуун тавин сая)-ийг буцаан төвлөрүүлэх нөхцөлтэйгээр олгосугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 150,000,000 төгрөгийг аймгийн Хөшөөт хөгжил санд 2022 онд төвлөрсөн орлогоос санхүүжүүлэхийг аймгийн Хөшөөт хөгжил сангийн захирал (Т.Мягмардорж)-д зөвшөөрсүгэй.

3. Урьдчилан олгосон санхүүжилтийг "Бадамлах дөл компани"-аас халаалт авдаг төсвийн байгууллагуудын батлагдсан халаалтын зардлаас 2022 оны 10 дугаар сард багтаан тооцож буцаан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д даалгасугай.

4. Байгууллага, иргэдэд дулаан түгээх ажиллагааны 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, урьдчилгааг хугацаандаа тооцоо хийж төвлөрүүлэхийг "Бадамлах дөл" компаний захирал (Д.Сурмаажав)-т зөвлөсүгэй.

Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2661
Zah /517 Bo